

Төслийн нэр: Тува СЭЭБХ – Тува бахархал

Хэсэг I: Төсөл санаачлагчийн мэдээлэл

Аймаг/ хот: Баян-Өлгий аймаг
Сум /дүүрэг: Цэнгэл сум , Хөшөөт төв
СЭЭБХ-ны хаяг: Цэнгэл сумын ЕБ-ын 2 дугаар сургуулийн СЭЭБХ, 05 тоот өрөө
СЭЭБХ-ны зохицуулагчийн овог, нэр: Бадарч овогтой Жаргалсайхан

Хэсэг IIa. Нөхцөл байдлын шинжилгээ

Дотоод хүчин зүйлс	
<p>Давуу тал</p> <ul style="list-style-type: none"> ✓ Сургуульд өөрийн гэсэн орон байртай, хичээлээс гадуур үйл ажиллагаа явуулах бүрэн боломжтой ✓ Үдээс хойш дугуйлан, секц хичээллүүлэх бүрэн боломжтой ✓ Багш суралцагчдын авьяас, чадварыг нээн илрүүлэх, тулж ажиллах ✓ Тува сургуулийн багш нар багаараа хамтран ажиллах чадвартай ба 1-5 ангийн Эх хэлний сурах бичгээ зохиосон ✓ Хос хэлний хөтөлбөрөөр хичээллэдэг. Монгол Тува хос хэлээр суралцдаг ✓ 1-р ангийн бүх сурах бичгийг Тува хэл дээр орчуулсан ✓ Төр засгаас зөвхөн бага ангид сургалтын хэрэглэгдэхүүн болох номыг үнэ төлбөргүй өгч байгаа ✓ Багш нар орчин үеийн техник хэрэгслийг ашиглах чадвартай ✓ Багшийн мэргэжил дээшлүүлэх, бусад бүх төрлийн сургалтанд болон ОХУ-ын Тува улсад туршлага солилцох сургалтанд хамрагдаж байгаа ✓ Бидний онцлог нь: хэл, соёл, түүхээ, өв соёлоо хадгалж үлдэхийн тулд эрмэлздэг. 	<p>Сул тал</p> <ul style="list-style-type: none"> ➢ Материаллаг болон ёс заншил, оюун ухааны чиглэлийн төсөл хөтөлбөрт хамрагдаж байгаагүй ➢ Үндэсний тоглоом наадгай, язгуур урлаг, хөгжмийн зэмсгээр сургалт дугуйлан секц хичээллүүлэх шаардагдах тоног төхөөрөмж байхгүй ➢ Материаллаг орчин дутагдсанаас хүүхдүүд чөлөөт цагаа өнгөрүүлэх урлагийн заал, хөгжилийн танхим байхгүй ➢ Эх хэлээр хүүхдүүд сурдаг ч математик сэтгэлгээний ур чадварыг үнэлдэг үнэлгээний арга зүйг боловсруулах нь дутмаг ➢ Сургалтын номыг үнэгүй ашиглуулж байгаа боловч нэмэлт хэрэглэгдэхүүн бусад дугуйлан, секц хичээллүүлэх ном сурах бичиг байхгүй ➢ Суралцагч нарт зөвхөн сурах бичгээс өөр нэмэлт ном байхгүй ➢ Эцэг эх, багш, суралцагчийн гурвалсан холбоо сайн идэвхжээгүй ➢ Хүүхдийн чөлөөт сэтгэн бодох, оюун ухааныг хөгжүүлэх оньсон тоглоомнууд байхгүй. ➢ Тус сургуулийн эцэг эхчүүдийн дийлэнх хувь нь малчин учир оролцоо сул тул уг төсөл
Гадаад хүчин зүйлс	
<p>Боломж</p> <ul style="list-style-type: none"> ✓ Бага ангийн багш, эцэг эх нар хамтарч ажилласнаар аливаа асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжтой. Жишээ нь: Тус сургуулийн бага ангийн багш нар багаараа эх хэлээрээ сурах стандарт 	<p>Эрсдэл</p> <ul style="list-style-type: none"> ✓ Тува үндэстэн өөрийн гэсэн түүх, ёс заншил, хэл, соёлтой боловч сүүлийн жилүүдэд мартагдаж байгаа ✓ Казак хэл, амьдрах орчин нийгэмшилд нөлөөлж байна

<p>шаардлагад нийцсэн сурах бичгийг зохион хэвлүүлсэн.</p> <p>✓ Эцэг эхтэй хамтарч ажиллах нь бага боловсролын тулгамдсан асуудлуудыг шийдэх боломжтой учир энэ боломжтой</p> <p>✓ Бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж байгаа</p> <p>✓ Багш нар бусад сургуулийн багш нартай хамтран ажиллаж өөрийгөө хөгжүүлэх дур сонирхолтой</p> <p>✓ Тува түмний хэл, соёл, түүх, өв соёл, язгуур урлаг, урлаг спортыг хадгалж үлдэхийн тулд “Хей-Аът” наадмыг 10 жил зохион явуулсан төрийн бус байгууллагууд</p>	<p>✓ Төр засгаас нийгмийн дэмжлэг байхгүй. Хэрэгцээт мэргэжлийн болон хөгжлийн зүйлээр хангадаггүй.</p> <p>✓ Дугуйлан, секц сурагчийн авьяас хөгжүүлэх тал дутмаг</p> <p>✓ Тува иргэдийн хот суурин газрууд руу нүүдэллэх, болон шилжилт хөдөлгөөн их</p> <p>✓ Хүүхдийн тоо цөөрөх шинжтэй</p> <p>✓ Эх хэл болон ёс заншлаа хэрэгцээгүй зүйл хэмээн үл хүндлэх байдалтай зарим хүмүүс өөр бусдадаа нөлөөлдөг</p>
---	--

Хэсэг IIб. Төслийн зорилго, хамрах хүрээ

Зорилго	Тува түмний уламжлалт ёс заншил, язгуур урлагийг эцэг эхийн оролцоотойгоор судалж, бага ангийн суралцагсдад эх хэл дээр нь ойлгуулж, сурталчилснаар тува үндэстний бахархалтай бие хүн болж төлөвшнө.
Хамрагдах хүний тоо	Тус сургуулийн нийт 127 суралцагч, 12 багш, удирдах ажилтан 3, эцэг эх 96, СЭЭБХ-ны нийт гишүүд 300 гаруй эцэг эх төслийн үр шимийг хүртнэ.

Хэсэг III. Төслийг хэрэгжүүлэх зохион байгуулалт ба ажлын төлөвлөгөө

ДД	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн	Хугацаа	Хүрэх үр дүн
1.	Төслийн нээлт	СЭЭБХ-ны Удирдах зөвлөл	2019 оны 5-р сард	Сумын хэмжээнд төслийн нээлтээ хагас өдрөөр төлөвлөж, хөтөлбөр гаргана. Сумын, сургуулийн удирдлага, сумын бусад сургуулийн төлөөлөл, иргэд, эцэг эх, малчин эцэг эхийг урина. Энэ үйл ажиллагаагаар төсөл болон СЭЭБХ-ны үйл ажиллагааг танилцуулна, гишүүнчлэлээ нэмэгдүүлнэ.
2.	СЭЭБХ-ны гишүүд багаар ажиллана: • Ёс заншлын баг • Язгуур урлагийн баг	СЭЭБХ-ны Удирдах зөвлөл	2019 оны 6.15-7.10	Багууд тува ёс заншил, язгуур урлагийн яг юу нь мартагдаж байгааг нутгийн ардаас судалгаа хийж, цаашид уламжлуулан авч үлдэхэд юу хийх санал авна.
3.	Судалгаа хийх бэлтгэл ажлыг хангана	СЭЭБХ-ны Удирдах зөвлөл, багийн гишүүд	2019 оны 8.15-9.15 хүртэл	Багийн гишүүд тэмдэглэл хөтлөх, зураг авах үүргээ хувааж авна. Бичлэг хийж, баримтжуулах чадвартай хүнийг дараа баримтат кино хийх зорилгоор ажиллуулна.

				Судалгааны үр дүнг гаргаж, хийх ажлыг төлөвлөнө.
4.	Багууд судалгааны үр дүнг танилцуулах	СЭЭБХ, багийн гишүүд	2019 оны 9-р сард	Бүх эцэг эх, багш, сумын иргэдэд судалгааны үр дүн, хийх үйл ажиллагааг танилцуулна.
5.	“Тува СЭЭБХ – Тува бахархал” өргөөг байгуулах	СЭЭБХ, багийн гишүүд	2019 оны 9-10-р сард	Эцэг эх, сурагч, багш нар хамтран баяжуулна. Тува үндэстний тоглоом, гар урлалын бүтээлүүд байх бөгөөд жуулчдад үзүүлж, ном, гар урлалын бүтээлээ борлуулж хөрөнгө босгож байнга ажиллуулна. Сурагчид чөлөөт цагаа эцэг эхтэйгээ хамт өнгөрүүлэх үйл ажиллагаа, цагийн хуваарьтай байна.
6.	“Тува СЭЭБХ – Тува бахархал” шторк (богино хэмжээний видео) хийх	СЭЭБХ, багийн гишүүд	2019 оны 11-12-р сард	Судалгааны багийнхны мэдээлэл, баримжуулалтыг ашиглаж хийнэ. Сурагчид, жуулчдад зориулсан баримтжуулалт болно.
7.	“Тува СЭЭБХ – Тува бахархал” өдөрлөг зохион байгуулах	СЭЭБХ, багийн гишүүд	2020 оны 1-р сард	Бүх сурагч, сумын иргэд, удирдлагуудад шторкоо үзүүлж, нутгийн ахмадуудыг урьж мартагдаж буй ёс заншил, язгуур урлагийн талаар яриулж, эцэг эх, сурагчдыг оролцуулан тоглолт зохион байгуулна. Энэ тоглолтоо жуулчдад сонирхуулж хөрөнгө босгох тогтмол номеруудтай болно.
8.	“Тува СЭЭБХ – Тува бахархал” том ном бүтээх	СЭЭБХ, багийн гишүүд	2020 оны 2-4-р сард	Анги бүрийн эцэг эх, сурагчид хамтран шторк, өдөрлөгөөс сурсан мэдсэнээрээ “Тува СЭЭБХ – Тува бахархал” өргөөнд том ном бүтээнэ.
9.	Цэнгэл сумын ардын авъяастан 2 зочин багш урьж хамтран ажиллах	СЭЭБХ	2020 оны 5-р сард	“Тува СЭЭБХ – Тува бахархал” өргөөнд явуулах үйл ажиллагаанд оролцоно. Дугуйлан, секц хичээлүүлэх, эх хэл заах, хөөмий, игил, довшуур бие биелгээ заана.
10.	Эцэг эхчүүдэд зөвлөмж гаргах	СЭЭБХ, зочин багш	2020.5-6-р сард	Тува хэл, Монгол хэлний авиа дуудлагын эцэн хчүүдэйд зориулсан зөвлөмж гаргах
11.	Судалгааны үр дүнгээс төлөвлөсөн ажлуудыг зохион байгуулна.	СЭЭБХ, багийн гишүүд	2020-9-р сараас	Тува түмний мартагдаж буй ёс заншил, язгуур урлагийг сурталчлах, түгээн дэлгэрүүлнэ.
12.	Төслийн үр дүнгийн чуулган	СЭЭБХ, сургуулийн удирдлага	2020 оны 9-р сарын сүүлийн 7 хоногт	Төслийн болон СЭЭБХ-ны үйл ажиллагааг дүгнэж, цаашдын тогвортой байдлын үйл ажиллагааны танилцуулах, “Тува СЭЭБХ – Тува

				бахархал” тайлан тоглолт зохион байгуулна.
--	--	--	--	--

Хэсэг IV Зардлын задаргаа

Зардлын төрөл		Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ, төг	Нийт үнэ, төг	Тус бүрт нь хүрэх үр дүнг бичнэ.	
Сургалтын хэрэглэгдэхүүн, материалын худалдан авалт	Үзүүлэн самбар	ш	4	60,000	240,000	“Тува СЭЭБХ – Тува бахархал” өргөөг тохижуулахад хэрэгтэй зүйлс: Тува түмний бахархал болсон хүмүүсийн намтар түүхтэй танилцах, бахархах, самбарт тавьсан бүтээлээс түүх соёлын өвийг мэдэж авна Үндэсний тоглоом, хөгжмөөр тоглож сурна.	
	Бахархлын булан	Эцэг эхийн оролцоотой өөрсдөө бүтээнэ.					
	Зургийн жааз	Эцэг эхийн оролцоотой өөрсдөө бүтээнэ.					
	Зураг угаалгах	ш	20	6000	120,000		
	Хорол (Тува үндэстний тоглоом)	ш	5	40,000	200,000		
	Сын чадраа (Тува үндэстний тоглоом)	Эцэг эхийн оролцоотой өөрсдөө хийнэ.					
	9 цагираг	5-р ангийн сурагчдаар дугуйлангийн хичээлээр хийлгэнэ.					
	Шагай (100 ш)	Эцэг эхийн оролцоотой өөрсдөө бүрдүүлнэ.					
	“Кыр” тоглоом	Эцэг эхийн оролцоотой өөрсдөө хийнэ.					
	Хомус (Тува үндэстний хөгжим)	ш	3	65,000	195,000		
	Довшуур (Тува үндэстний хөгжим)	ш	2	150,000	300,000		
	Игил (Тува үндэстний хөгжим)	ш	2	150,000	300,000		
	Дорож	ш	5	80,000	400,000		
Тавиур	ш	4	50,000	200,000			
Зөвлөх үйлчилгээни	Зочин багшийн урамшуулал			600,000	600,000	“Тува СЭЭБХ – Тува бахархал” өргөөнд явуулах үйл ажиллагаанд оролцоно. Дугуйлан, секц хичээлүүлэх, эх хэл заах, хөөмий, игил, довшуур бие биелгээ заана.	
Сургалтын	Ватум цаас	ш	20	1200	24,000	Судалгаа, том ном бүтээх, уулзалтын урилга хийх зэрэгт ашиглана.	
	Бичгийн цаас	боодол	1	50,000	50,000		
	Өнгийн цаас	ш	50	300	15,000		

	Маркер	ш	10	1000	10,000	
Үйл ажиллагааны зардал	Төслийн нээлт				150,000	Энэ үйл ажиллагаагаар төсөл болон СЭЭБХ-ны үйл ажиллагааг танилцуулна, гишүүнчлэлээ нэмэгдүүлнэ.
	Төслийн үр дүнгийн чуулган				200,000	Төслийн болон СЭЭБХ-ны үйл ажиллагааг дүгнэж, цаашдын тогвортой байдлын үйл ажиллагааны танилцуулах, “Тува СЭЭБХ – Тува бахархал” тайлан тоглолт зохион байгуулна.
	Эцэг эхчүүдэд зөвлөмж гаргах	ш	50	2500	125,000	Эх хэл бол бахархал учир Тува хэл Монгол хэлний авиа дуудлагын зөвлөмж гаргах
	“Тува СЭЭБХ – Тува бахархал” өдөрлөг				250,000	Бүх сурагч, сумын иргэд, удирдлагуудад шторкоо үзүүлж, нутгийн ахмадуудыг урьж мартагдаж буй ёс заншил, язгуур урлагийн талаар яриулж, эцэг эх, сурагчдыг оролцуулан тоглолт зохион байгуулна.
	Гарын авлага хийх		125	2000	250.000	“Ёс заншил бахархал” сэдвээр гарын авлага боловсруулах, ном хийх анги тус бүрээр. Эцэг эхчүүдийн оролцоотойгоор хийнэ. Номыг худалдан авахгүй шаардагдах материалыг худалдан авч эцэг эхтэй хамтарч багш нар хийнэ.
	Ёс заншил, язгуур урлагийн багуудын зардал:	удаа	3	20,000	500.000	Багууд тува ёс заншил, язгуур урлагийн яг юу нь мартагдаж байгааг сумын төв болон алслагдсан багуудын нутгийн ардаас судалгаа хийж, багийн гишүүд тэмдэглэл хөтлөх, зураг авах үүргээ хувааж авна. Хийсэн ажлын үр дүнг сурагч, эцэг эх, багш, сургууль, олон нийтэд танилцуулна. Судалгааны багт урамшуулал өгнө.
	Төлөвлөх, дүгнэх уулзалтын зардал				60,000x2	
	Харилцаа холбооны зардал				40,000x2	
Багийн урамшуулал	150,000x2					
	л	200	2000	400.000	Судалгааны 2 багийн замын зардал буюу бензин /сумын эргэн тойронд ойролцоогоор820 км/	

	“Тува СЭЭБХ – Тува бахархал” шторк (богино хэмжээний видео) хийх				300.000	Ёс заншил, язгуур урлагийн багуудын хүмүүстэй хамт явах мэргэжилийн бичлэг хийх, баримтжуулах чадвартай хүнийг ажиллуулна.
		м	30	5000	150.000	Дээрх бичлэгүүдийг нэгтгэж богино хэмжээний видео хийх
	Харилцаа холбооны зардал	нэгж	10	5000x2	100,000	СЭЭБХ-ны УЗ-ийн гишүүдийн үйл ажиллагааны зардал
	Интернэт				50,000	
	Уулзалтын зардал	удаа	15	10.000	150.000	
	Банкны шимтгэл				36,940	
Бүгд					5.315.940	Монгол банкны 2019.1.8-ны өдрийн ам.долларын ханш 2657.97

Хэсэг VI Төслийн тогтвортой байдал

Төслийг хэрэгжүүлснээр:

- Тува үндэстний мартагдаж буй ёс заншил, язгуур урлагийн болон г соёлын бүтээл, тоглоом наадгай, хөгжмийн зэмсэг, сэтгэх чадвар, оюуны хөгжлийн бүтээлүүдээр байнга үргэлжлүүлэн баяжуулж урлаг, соёл, түүхийн сан бий болгох,
- Эцэг эх, багш хамтран ажиллаж зөвлөмж, гарын авалга боловсруулснаар ирээдүй хойч үедээ суралцах суралцагчдад хөрөнгө оруулалт болох болно.
- Тува түмний уламжлалт ёс заншил, язгуур урлагийг эцэг эхийн оролцоотойгоор судалж, бага ангийн суралцагсдад эх хэл дээр нь ойлгуулснаар багш, эцэг эхийн эргэх холбоо улам сайжирна. “Тува СЭЭБХ – Тува бахархал” өргөөг байгуулснаар сурагчид, эцэг эх, багш нар цаашид баяжуулан хөгжүүлснээр тува үндэстний тоглоом, гар урлалын бүтээлүүдийг гадаад, дотоодын жуулчдад үзүүлж, ном, гар урлалын бүтээлээ борлуулж хөрөнгө босгож байнга ажиллуулна.
- Сурагчид чөлөөт цагаа эцэг эхтэйгээ хамт өнгөрүүлэх орчин бий болно.

Төслийн саналыг дэмжсэн гишүүдийн гарын үсэг, нэр :

СЭЭБХ-ны Зохицуулагч:

Бадарч овогтой Жаргалсайхан /Гарын үсэг...../

Төслийг боловсруулсан СЭЭБХ-ны гишүүн, багш:

Нацаг овогтой Ганбаатар /Гарын үсэг...../

Төслийг боловсруулсан:	Эцэг эх / С.Хүдэрцэцэг/	Огноо: 2019 он 01 сарын 01 өдөр
	Эцэг эх / У.Адьяа/	
	Эцэг эх / Сонинчичэг/	
	Багш / Э.Шагдар/	ТАМГА
	Багш / З.Нарантуяа/	
	Багш / С.Алтанзул/	
	Багш / М.Цэцэгээ.../	